



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/143

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн, 50.1.1 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалаар баталсан журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын урсгал төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Ундрага-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шатахуун нийлүүлэх худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Т.Сүхбаатар	(Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)
Нарийн бичиг:	Ү.Баттулга	(Иргэдийн хурлын мэргэжилтэн)
	Д.Нарандулам	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Т.Сүхбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ